

МОНГОЛ УЛС, БНХАУ-ЫН ХООРОНДЫН ХУДАЛДАА, ЭДИЙН ЗАСГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ЦААШДЫН ЧИГ ХАНДЛАГА

Эрхэм хүндэт Төлөөлөгчид Та бүгдийн энэ өдрийн амгаланг айлтгая,

Ийнхүү-Оюудайн бил орчмын ажлын хөгжүүлэх асуудлаар та бүхэнтэй санал бодлоо солилцох энэхүү боломж олдсонд олзуурхаж байна. Боломжийг бүрдүүлэн хийж байгуулахад хүчин зүтгэсэн АИОАБ-ийн Цагаарчид, Ажлын дараагийн ажил, Монгол Оюунд Найрсаг уламжлал илэрхийлье.

Монгол, Хятад хоёр орон олон зууныг дамнасан түүхэн, уламжлалт харилцаатай орнууд.

Монгол, Хятадын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаа өнөөдөр хамгийн тааламжтай үедээ байна. Хоёр орны харилцаа, хамтын ажиллагаа бийррэн, үзэгдэлтэй, нийгмийн бүх салбарыг хамран амжилттай хөгжиж байна.

Өнөөдөр хоёр орны харилцаа, хамтын ажиллагааны асуудлуудыг зохицуулсан 100 гаруй гэрээ, хэлэлцээр үйлчилж байна.

Монгол, Хятадын Найрсаг, харилцаа, хамтын ажиллагааны тухай гэрээнд 1994 онд Улаанбаатар хотод гарын үсэг зурсан. Энэхүү гэрээнд хоёр улсын сайн хөршийн найрсаг харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх үндсэн зарчмыг тодорхойлон заасан болно.

2003 онд хоёр талын харилцаа, хамтын ажиллагааг сайн хөршийн найрсаг, харилцан итгэлцсэн түншийн харилцаа гэж санал нэгтгэж тодорхойлсон бий.

Манай хоёр улсын худалдаа, эдийн засгийн харилцааг зохицуулагч ажлын механизм болох “Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол улсын засгийн газар, БНХАУ-ын засгийн газар хоорондын Комисс” тогтмол хуралдаж, үйл ажиллагаагаа хэвийн явуулж ирлээ. Засгийн газар хоорондын Комисс нь 1991-2008 онуудад нийт 11 удаа хуралдаад байна. Үүнийг ийнхүү Ажлын дараагийн ажил, Монгол Оюунд Найрсаг уламжлал илэрхийлье.

Худалдаа

Хятад улс нь манай гадаад худалдааны хамгийн том түнш юм.

1990 онд хоёр талын хооронд хийгдсэн худалдааны хэмжээ дөнгөж 33,6 сая ам доллар байсан бол 2008 оны үзүүлэлтээр 2,8 тэрбум ам.доллар болж 18 жилийн хугацаанд 83 дахин өсчээ.

Сүүлийн жилүүдэд Монгол, Хятадын хоорондын худалдааны хэмжээг үзүүлбэл:

/сая ам.доллараар/

	1990	1991	1992	1993	1994	1995
Нийт эргэлт	33.6	69.1	126.9	186.1	84.2	112.6

Экспорт	11.3	52.8	69.4	120.2	62.8	73.2
Импорт	22.3	16.3	57.6	65.9	21.4	39.4

	1996	1997	1998	1999	2000	2001
Нийт эргэлт	139.0	158.5	143.4	255.7	377,2	314.1
Экспорт	75.0	60.3	88.4	191.7	267,07	200,6
Импорт	64.0	98.2	55.0	64	109,5	113,5

	2002	2003	2004	2005	2006	2007
Нийт эргэлт	360.0	448.2	661.3	811,0	1450,3	2071,5
Экспорт	220	276.6	407.8	505,2	1046,5	1406,9
Импорт	140	171.5	253.5	305,8	403,8	664,6

	2008	2010	2011	2012	2013	2014
Нийт эргэлт	2814,0					
Экспорт	1631,3					
Импорт	1182,7					

Сүүлийн 3 жилийн байдлаар хоёр талын хооронд хийгдсэн худалдааны хэмжээ жил бүр 35-70 хувиар өссөн үзүүлэлттэй байгаа нь хоёр талын харилцаа, хамтын ажиллагаа хур эрчимтэй өрнөж байгааг харуулж байна.

Хөрөнгө оруулалт

Хятадаас ᠒᠒᠗᠗᠗ ᠔᠔᠔ ᠔᠔᠔᠔᠔ хөрөнгө оруулалт жил ирэх тутам нэмэгдэж ирлээ. Монгол Улсад оруулсан гадаадын хөрөнгө оруулагч орнуудыг Хятад Улс сүүлийн 8 тэргүүлсэн хэвээр байна. 2008 оны байдлаар БНХАУ-ын **1,6 тэрбум** ам.долларын хөрөнгө оруулалттай 4595 аж ахуйн нэгж бүртгэгджээ. Хөрөнгө оруулалтын хэмжээ сүүлийн 4 жилд 3,7 дахин, хөрөнгө оруулсан аж ахуйн нэгжийн тоо 4 дахин нэмэгдсэн байдаг. Хятадаас оруулсан хөрөнгийн 67,3 хувийг геологи, уул уурхайн салбарт, 20 орчим хувийг худалдаа, нийтийн хоолны салбарт оруулсан ааааа.

Монгол улсаас БНХАУ-д хөрөнгө оруулалт хийсэн пүүс, компани аж ахуйн нэгж маш бага байна. Өнөөдөр 40 гаруй аж ахуйн нэгж Хятадад үйл ажиллагаа явуулдаг гэсэн тоо мэдээ байдаг.

Монгол Улсаас БНХАУ-д хөрөнгө оруулах үйл ажиллагаа бараг байхгүй байгаагийн гол учир нь манай аж ахуйн нэгжүүдийн хүчин чадал, өрсөлдөх чадвар сул, техник, технологийн түвшин хүрэлцэхгүй байгаа, Хятадын зах зээлд нэвтрэх хууль эрхзүйнг орчин бүрэн судалж чадахгүй байгаа зэргээс хамаарч байна гэж дүгнэж болно.

Монгол улсад БНХАУ-аас олгосон зээл, үзүүлсэн буцалтгүй тусламж

Монгол, Хятадын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны салшгүй нэг хэсэг нь БНХАУ-аас Монгол Улсад олгож буй зээл, тусламж, түүгээр хэрэгжүүлж буй төслүүд байдаг.

Хятадын талаас хамгийн анх 1958 онд 22,5 сая, 1960 онд 45,0 сая шилжих рублийн зээлийг жилийн нэг хувийн хүүтэй, 1962-1976 онд экспортын бараагаар төлөх нөхцөлтэйгээр олгосон.

1991 онд 50 сая, 1992 онд 30 сая, 1994 онд 50 сая юанийн хүүгүй зээлийг БНХАУ-ын Засгийн газраас тус тус олгосон бөгөөд тэдгээрийг шаардлагатай бараа материал худалдан авах, төслүүдийг санхүүжүүлэх зэрэг чиглэлээр бүрэн авч ашигласан билээ.

2001 болон 2005 онд олгосон нийт 200 сая юанийн хөнгөлөлттэй зээлийг Сүхбаатарын цайрын орд газарт ашиглахаар хоёр улсын Засгийн газар хооронд тохиролцож төслийг хэрэгжүүлсэн нь нэг талаар БНХАУ-аас манайд оруулсан хамгийн үр дүнтэй хөрөнгө оруулалтын төсөл болсон гэж үздэг.

2008 оны байдлаар нийт 46.1 сая шилжих рубль, 330 сая юаны зээл олгоод байна.

БНХАУ-аас БНМАУ-д /хуучин нэрээр/ эдийн засаг, техникийн тусламж үзүүлэх тухай 1956 он болон 1960 оны Хэлэлцээрээр **36.0 сая рублийн** буцалтгүй тусламж олгосон байсан нь манайд олгосон буцалтгүй тусламжийн эхнийх гэж үзэж болно.

2008 оны байдлаар нэгтгэн дүгнэж үзвэл БНХАУ-аас Монгол Улсад нийт 36 сая шилжих рубль, 540 гаруй сая юань, 4,100.0 мянган ам. долларын буцалтгүй тусламж олгоод байна.

Салбарын харилцаа, хамтын ажиллагаа

Сүүлийн жилүүдэд уул уурхай, барилга, зам, тээвэр, ХАА, банк, санхүүгийн бүхий л салбарт хоёр талын төрийн болон төрийн бус байгууллагууд шууд харилцах харилцаа нэмэгдэж, хамтын ажиллагааны гэрээ хэлэлцээр байгуулах, мэргэжилтэн солилцох, арга туршлагаасаа суралцаж байгаа нь хамтын ажиллагааг өргөжүүлэх чухал хөшүүрэг болж байна.

Аялал жуулчлалын салбарт

БНХАУ манай орныг хятадын жуулчид өөрийн зардлаар жуулчлах орны жагсаалтад оруулсан нь аялал жуулчлалын салбарт хамтын ажиллагаа хөгжүүлэх чиглэлд гарч байгаа нааштай хандлагын эхлэл юм.

Сүүлийн жилүүдэд хоёр орны хооронд иргэд харилцан зорчих явдал эрс нэмэгдэж байна. ХХЕГ-ын мэдээгээр 2008 онд БНХАУ-ын 200 гаруй мянган иргэн манай оронд ирсэн бол манай 790 гаруй мянган иргэн БНХАУ-д болон БНХАУ-аар дамжин 3 дахь оронд зорчжээ.

Авто тээврийн чиглэлээр

БНХАУ-тай авто тээврээр хийгдэж байгаа улс хоорондын ачаа, зорчигч тээвэрлэлтийн үйл ажиллагааг Монгол улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хооронд 1991 онд байгуулсан Автотээврийн хэлэлцээр, түүнийг хэрэгжүүлэх тухай протокол, нарийвчилсан журмын хүрээнд зохион байгуулж, хяналт тавьж байна.

Өнөөгийн байдлаар Монгол–Хятадын хилийн байнгын болон түр ажиллагаатай 12 боомтоор ачаа, зорчигч тээвэрлэгдэж байгаа ба сүүлийн жилүүдэд манай улсад ашигт малтмал түүний дотор нүүрс, *айсдүй өйиү* олборлолт ихээхэн нэмэгдэж тээвэрлэлтийн хэмжээ огцом өсч байгаа нь *об÷ей* Автотээврийн хэлэлцээрийн хүрээнд шийдвэрлэх боломжгүй асуудлуудыг *өйя°б* боллоо.

Иймээс БНМАУ-ын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын Автотээврийн хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах хоёр талын ажлын хэсгийг байгуулах хэлэлцээг явуулж эхлээд байна.

Манай улс 2001 онд “Олон улсын хэмжээнд ТИР карнейг хэрэглэн тээвэрлэлт гүйцэтгэх гаалийн Конвенц”-д нэгдэн орсноор дамжин өнгөрөх тээвэрлэлтийг олон улсын хэмжээнд гүйцэтгэх эрх зүйн орчин бүрдсэн бөгөөд тээвэрлэгч аж ахуйн нэгж, иргэд ч зохих нөхцөл шаардлага хангасан тээврийн хэрэгсэлтэй болж, тээвэрлэлт гүйцэтгэж байна. Эдгээр тээвэрлэгчдэд манай талаас хамгийн ойр далайн боомт болох БНХАУ-ын Тяньжин боомт руу тээвэрлэлт хийх бодит хэрэгцээ шаардлага байгаа юм.

Иргэний нисэхийн салбарт:

Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хооронд байгуулсан Иргэний агаарын тээврийн тухай хэлэлцээрийн дагуу МИАТ ХК, Эйр Чайна компаниуд Улаанбаатар-Бээжингийн чиглэлд, Аэромонголиа ХХК нь Улаанбаатар-Хөх хотын чиглэлд томилогдон тогтмол нислэг гүйцэтгэдэг. Улаанбаатар–Бээжингийн хооронд МИАТ компани 1987 оноос, Хятадын Air China компани 1991 оноос тогтмол нислэг хийж байна.

2008 оны 1 дүгээр сард хоёр талын Иргэний нисэхийн удирдах газар хооронд хийсэн уулзалтаар Улаанбаатар, Бээжин хооронд хийгдэх нислэгийн тоог долоо хоногт 14 хүртэл, Улаанбаатар, Бээжингээс бусад чиглэлд хийгдэх нислэгийн тоог долоо хоногт нийтдээ 14 хүртэл байх, ингэхдээ аль чиглэлд хэдэн нислэг хийх асуудлыг талууд өөрийн эрх мэдлийн хүрээнд шийдвэрлэхээр, мөн ачаа тээвэрлэлтийн нислэгийн тоог долоо хоногт 10 хүртэл байхаар тус тус тохирсон.

Төмөр замын салбарт:

Улаанбаатар–Бээжин, Улаанбаатар–Хөх хотын хооронд суудлын галт тэрэг тогтмол явж байна. Зорчигчдын тоо эрс өсөж байгаатай уялдуулан Улаанбаатар–Бээжингийн хооронд зуны улиралд нэмэгдэл галт тэрэг аялуулахаар хоёр тал тохиролцон хэрэгжүүлж байгаа болно. Замын Үүд–Эрэн хотын хооронд зорчигч тээврийн автобусны байнгын үйлчилгээг 1992 оноос нээж үй.

Ачаа тээвэрлэлт төмөр замын одоогийн байгаа хүчин чадлын хэмжээнд хүрэхгүй байна. Хятадын төмөр зам Монголоос ирэх ачааг хүлээх авах бүрэн боломжтой, харин Монголын талаас их хэмжээний ачааг хүлээн авахад техник технологийн хувьд бэлэн биш байгаа юм. Иймээс Замын-Үүд өртөөний ачаа шилжүүлэн ачих байгууламжийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, Замын-Үүдэд шинээр байгуулж байгаа автомашинаас вагонд ачаа ачих шинэ терминалын аж ахуйг даруй ашиглалтанд оруулах шаардлага байгаа болно.

Монголд шинээр төмөр замыг барихад гадны хөрөнгө оруулалтыг татан оролцуулах шаардлага байгаа бөгөөд хятадын талын хөрөнгө оруулалтыг Засгийн газраас зарчмын хувьд дэмжиж байгаа болно.

Авто замын салбарт:

Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд авто замын үүрэг эрс нэмэгдэж авто замын бүтээн байгуулалтын ажил сүүлийн жилүүдэд эрчимтэй явагдаж ирсэн. Үүнтэй холбогдон гадаадын хөрөнгө оруулалтын тодорхой хэсэг энэ салбарт орж байна. Ялангуяа БНХАУ-ын аж ахуйн нэгжүүдээс энэ салбарт хөрөнгө оруулах, бүтээн байгуулалтын ажилд гүйцэтгэгчээр ажиллах явдал эрс нэмэгдсэн. Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Мянганы зам” төслийн ажилд Хятадын пүүс, компаниуд идэвхтэй оролцож байна. Энэ төслийн хүрээнд монголын урд, хойд хилийг холбох баруун босоо тэнхлэгийн авто замыг барихад Азийн хөгжлийн банк 37.6 сая ам.долларын буцалтгүй тусламжийг үзүүлэхээр болж энэ оны 4 дүгээр сарын 18-ний өдөр Буцалтгүй тусламжийн гэрээнд гарын үсэг зурсан. Энэ чиглэлд нийт 748.4 км замыг барихад 199.5 сая ам.долларын хөрөнгө шаардлагатай байгааг урьдчилан тооцсон бөгөөд Азийн хөгжлийн банкны буцалтгүй тусламж, Монгол Улсын Засгийн газраас гарч буй санхүүжилтээр ойролцоогоор бүгд 220 км хатуу хучилттай авто замыг барих ба үлдсэн хэсэг дээр санхүүжилт шаардлагатай байгаа юм. БНХАУ-аас олгох 300 сая ам.долларын зээлийн хөрөнгөнөөс 50 сая ам.долларыг энэ замд олгох нь дэмжигдэн Зээлийн гэрээнд БНХАУ-ын дэд даргын айлчлалын үеэр гарын үсэг зураад байна.

Барилга, хот байгуулалтын салбарт:

Мөн 2008 оны 6 дугаар сарын 19-ний өдөр гарын үсэг зурсан “Монгол Улс, БНХАУ-ын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны дунд хугацааны хөтөлбөр”-т барилга, хот байгуулалтын салбарт 9 асуудал, зам, тээврийн чиглэлээр 12 асуудал тусгагдсан бөгөөд эдгээрийг хэрэгжүүлэх ажил эхлээд явагдаж байна.

Геологи, уул уурхайн салбарт

Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг хангагч гол салбар болох геологи, уул уурхайн салбар хоёр талын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны тэргүүлэх ач холбогдолтой чиглэл болохыг хоёр орны удирдлагууд санал нэгтэй хүлээн зөвшөөрсөн. Энэ утгаараа уул уурхайн салбарын хамтын ажиллагааг Засгийн газрын зүгээс бодлогын хэмжээнд дэмжлэг үзүүлэх, хөрөнгө оруулалтын томоохон төслүүдийг хэрэгжүүлэхэд Хятадын аж ахуйн нэгжүүдийг оролцуулах, газар нутаг, байгаль цаг уурын ойролцоо нөхцөл, зах зээл, хүн хүчний нөөц боломж, техник технологийн зөрүүтэй байдал зэрэг харилцан бие биенээ нөхөх давуу талуудыг бүрэн ашиглахыг зорьж ажиллаж байна.

2005 онд Бээжин хотод болсон Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол-Хятадын Засгийн газар хоорондын комиссын IX дугаар хуралдаанаар “Монгол-Хятадын Засгийн газар хоорондын комиссын Эрдэс баялгийн салбарт хамтран ажиллах дэд хороо”-а бaéābóéābāāд тогтсон.

Хамтын ажиллагааны цаашдын чиг хандлага

2008 онд аадуй гнуйа сдднй “Монгол, Хятадын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөр” нь 2008-2012 онд хоёр талын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх үндсэн чиглэлийг тодорхойлсон баримт бичиг болсон. Дунд хугацааны хөтөлбөрт хоёр талын харилцаа, хамтын ажиллагааны өнөөгийн түвшинг нааштайгаар үнэлж цаашид авах арга хэмжээний талаар салбар, чиглэл бүрээр тодорхой тусгаж өгсөн. Тухайлбал уг хөтөлбөрт “Хятад, Монголын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны зорилго нь найрсаг харилцааг үндэслэж хоёр улсын эдийн засгийн чадавхийг бүрэн ашиглах замаар бизнесийн орчинг улам бүр төгөлдөржүүлэх, хамтын ажиллагааны хүрээг өргөтгөх, олон хэлбэр, олон давхарга бүхий өндөр зэрэглэлийн худалдаа, эдийн засгийн харилцааны бүтцийг бий болгоно” гэж заасан билээ.

Энэ бүгдээс үзэхэд Монгол, Хятадын хоорондын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаа зогсолтгүй урагшлан хөгжих боломж нөхцөл, ирээдүй харагдаж байна.

Àíõààðàë òààüñàíà áàüðëàèà.